



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар A/66

Арвайхээр

**Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай**

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарыг 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллгааны хөтөлбөр батлах тухай” 03/03 тогтоолын 1.6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Салбар зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган, жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Салбар зөвлөл (С.Ундрах)-д үүрэг болгосугай.

3.Дээрх захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын “Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай” 2017 оны A/111 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100146

Аймгийн Засаг даргын 2021 оны 09
дугаар сарын 08-ны өдрийн 466 дүгээр
захирамжийн хавсралт

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН ОРОН НУТАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Салбар зөвлөлийн дарга: -Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: -Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн
захирал

Гишүүд: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн
бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн Засгийн газрын болон аймгийн Засаг даргын
үйл ажиллагааны хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн

-Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат
компанийн Өвөрхангайн салбарын ерөнхий инженер (зөвшилцсөнөөр)

-Онги Ус суваг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн
газрын ерөнхий инженер (зөвшилцсөнөөр)

-Өгөөмөр рашаан сувиллын захирал (зөвшилцсөнөөр)

-Хангамж-Өргөө ХХК-ний ерөнхий инженер (зөвшилцсөнөөр)

-Топ зүү ХХК-ний үйлдвэрийн дарга (зөвшилцсөнөөр)